



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/039

Номгон

Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын  
өдрийг тохиолдуулан нэгдсэн арга хэмжээ  
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж, дадлагажуулах гамшгийн эрсдэлийг бууруулахын ач холбогдлыг хүүхэд, залууст таниулах ажлыг зохион байгуулсугай.

2. Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдрийг зохион байгуулахад шаардагдах 2.175.000 /Хоёр сая нэг зуун далан таван мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

60110491

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар  
сарын 12-ны өдрийн А/639 дүгээр  
захирамжийн хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ӨЛӨН УЛСЫН  
ӨДРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Гар зургийн уралдааны зардал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Өргөмжлөл	9	15,000	135,000
2	Мөнгөн шагнал	9 сурагч "Тэргүүн байр"-100,000 Дэд байр" 80,000, Гутгаар байр 60,000	720,000	720,000
3	Жааз	9	20,000	180,000
4	Гамшгаас хамгаалах албадын арга хэмжээ	1	900,000	900,000
5	Хулдаасан хэвлэл	1	240,000	240,000
		<b>Нийт</b>		<b>2,175,000</b>

оОо